



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/268

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, орон нутгийн бүтээн байгуулалт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан нэр бүхий иргэдийг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 390000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 390000 төгрөг/гурван зуун ерэн мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДУГЭРЖАВ



Zax A/268 Ch  
02 01401

Аймгийн Засаг даргын 2019 оны  
05 дугаар сарын 03-ны өдрийн  
А/268 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР  
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Б.Өлзийбаатар	Манхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер	30000
2	Р.Бум-Эрдэнэ	Манхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш	30000
3	Ц.Нямтулга	ХААН банкны Чандмань сумын тооцооны төвийн харилцааны менежер	30000
4	Д.Бат-Эрдэнэ	ХААН банкны Дуут сумын тооцооны төвийн эрхлэгч	30000
5	Э.Энхцэцэг	Жаргалант сумын Наран багийн иргэн	30000
6	Б.Цэнд-Аюуш	Дөргөн сумын Агваш багийн иргэн	30000
7	Д.Баатарцогт	Дарви сумын малчин	30000
8	Р.Цэрэндорж	Дарви сумын малчин	30000
9	Н.Бүргэд	Алтай сумын ИТХ-ын дарга	30000
10	Н.Базаррагчаа	Дөргөн сумын ИТХ-ын дарга	30000
11	Б.Алтанзул	Аймгийн Улаан загалмайн хорооны ажилтан	30000
12	Г.Нямтайван	БОЭТ-ийн ахмад сувилагчдын холбооны гишүүн, сувилагч	30000
13	Д.Дончин	БОЭТ-ийн Ахмад сувилагчдын холбооны гишүүн, сувилагч	30000
<b>Дүн</b>			<b>390000</b>

-оОо-